



ӨМНӨХ ҮГ

Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Эрдэм шинжилгээний бүтээл” (Bulletin of Institute of Chemistry and Chemical Technology, BICCT) сэтгүүлийн Дугаар 12 буюу 2024 оны дугаар гарч байна. Манай сэтгүүлд сүүлийн үеийн судалгааны ажлын шинэлэг үр дүнгээрээ өгүүлэл бичиж ирүүлсэн эрдэмтэн судлаачид та бүхэнд талархал илэрхийлье.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт нийт 13 эрдэм шинжилгээний өгүүлэл хэлэлцэгдэн хянагдсанаас Монгол орны эмийн ургамлын фитохимийн судалгаа, эрдэс хүдрийн боловсруулалт, органик синтез, уурагт хаягдлын биотехнологийн боловсруулалт ба ашиглалт, говийн бүсийн гүний усны шинж чанарын талаарх судалгааны үр дүнгүүд сэтгүүлийн шаардлагыг ханган хэвлэгдэн гарч байна. Тодруулбал, органик химичид гэрлийн нөлөөнд хатуу төлөвт явагддаг урвалын кинетикийг термогравиметрийн аргаар судлах боломжтойг илрүүлсэн бол Г.Одонтуяа нарын гидрохимичид говийн бүсийн гүний худгуудын усан дахь фторын ионы судалгаагаар түүний зонхилох эх үүсвэр нь хайлуур жонш буюу флюоритын төрлийн эрдэс болохыг тогтоосон байна. Материал судлаачид цахилгаан станцын хаягдал үнснээс цэнэг хураагуур, 3D хэвлэл, нийлмэл материалын үнэт түүхий эд болсон цахиур болон хөнгөнцагааны оксидуудыг өндөр цэвэршилттэй гарган авахад саад бологч элемент болох төмрийн агуулгыг бууруулсан талаарх урьдчилсан дүнг нэгтгэн нийтлүүлжээ. М.Анударь нарын судлаачид арьс ширний үйлдвэрийн хаягдлыг боловсруулж гаргаж авсан уурагт түүхий эдийг өндөглөгч тахианы тэжээлийн нэмэлтээр ашиглах боломжтойг тогтоосон сонирхолтой үр дүнг гаргасан байна.

Эрхэм хүндэт эрдэмтэн судлаач та бүхнийг судалгаа шинжилгээний ажлынхаа шинэлэг үр дүнгүүдийг манай сэтгүүлд нийтлүүлэн олонд таниулж, шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэх, салбар дундын болон салбар дамнасан хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн төлөө хамтран ажиллахыг хүсэж байна.

Эцэст нь сэтгүүлийг эрхлэн гаргахад хамтран ажилладаг хөндлөнгийн шүүмжлэгчид, редакцын зөвлөлийнхөндөө гүн талархал илэрхийлье.

Улс орны хөгжлийн түлхүүр болсон Монгол улсын шинжлэх ухаан хөгжин цэцэглэх болтугай.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР ЛХАСҮРЭНГИЙН ЖАРГАЛСАЙХАН